



УВС АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА

2012 оны эхний 11 сар

- ӨНЭЗС-ны үр дүн 2012 оны 1, 2 дугаар улирлын байдлаар
- АХС-ны үр дүн 2012 оны 1, 2 дугаар улирлын байдлаар
- Ажиллагсадын тоо, дундаж цалингийн түүвэр судалгааны үр дүн 2012 оны 3 дугаар улирлын байдлаар

Улаангом хот

АГУУЛГА

Аргачлалын тайлбар	3
I. Нийгмийн үзүүлэлт	
1.1 Хүн ам	4
1.2 Нийгмийн даатгал, халамж, нөхөн олговор	4
1.3 Ажилгүй иргэд	5
1.4 Эрүүл мэнд	6-10
1.5 Гэмт хэрэг	11-12
II. Макро эдийн засгийн үзүүлэлт	
2.1 Хэрэглээний бараа үйлчилгээний үнэ	12-17
2.2 Орон нутгийн төсөв	
2.2.1 Орон нутгийн төсвийн орлого	17-19
2.2.2 Орон нутгийн төсвийн зарлага	19-20
2.2.3 Орон нутгийн төсвийн өглөг	21
2.3 Мөнгө зээл хадгаламж	22-23
2.4 Гадаад худалдаа	23-24
III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт	
3.1 Хөдөө аж ахуй	
3.1.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ	24-26
3.2 Аж үйлдвэр	26-32
IV Цаг уур	32
V . Хэрэглэгчдэд зориулсан лавлагаа	32

Хүснэгтэн мэдээллүүд

Аймгийн үндсэн үзүүлэлт	33
Бүртгэлтэй ажилгүйчүүд	34
Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт	34
Нөхөн олговор нийгмийн халамж	35
Нийгмийн даатгалын сангийн зарцуулалт /сумаар/	36
Эрүүл мэнд	36-37
Гэмт хэрэг	38
Хэрэглээний үнийн индекс	39-40
Зээл хадгаламж	40-42
Төсвийн орлого, зарлага, өглөг	43-46
Экспорт, импорт	47
Х А А –н бүтээгдэхүүний үнэ	48
Аж үйлдвэр	49-52
Цаг уур	53
Түүвэр судалгааны дүн :	
АХС- 2012 оны 1 дүгээр улирал	54-59
АХС- 2012 оны 2 дугаар улирал	60-65
ӨНЭЗС- 2012 оны 1, 2 дугаар улирал	66-69
Ажиллагсадын тоо, дундаж цалингийн судалгааны 3 дугаар Улирлын дүн	69-70

Аргачлалын тайлбар:**ОРОН НУТГИЙН ТӨСӨВ**

Төсвийн орлого зарлагын тооцоог Олон улсын Валютын сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн гаргаж байна. Төсвийн орлогын мэдээг аймгийн Татварын хэлтэс, төсвийн зарлага, санхүүжилтийн мэдээг СЭЗТС-ийн хэлтсээс гаргадаг.

Төсвийн орлогын мэдээг хэрэглэгчдэд илүү тодорхой болгох зорилгоор аймгийн нийт төсвийн орлого, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт, орон нутгийн төсвийн орлого, үүнээс улсын төсөвт /аймгийн/ төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлт гэж салгаж харууллаа.

Төсвийн зарлагыг эдийн засгийн салбарын ангиллаар гаргаж, улсын төсвийн байгууллагууд, орон нутгийн төсвийн байгууллагууд гэж тус тусдаа гарсныг нэгтгэж орууллаа.

ҮНЭ

Аймгийн төвийн хүсний зах дээр борлогдож байгаа хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн, ноосм, ноолуур, арьс шир зэрэг зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийг харуулав.

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь өрх орлогоороо өөрсдийн хэрэгцээнд худалдан авсан, үйлчлүүлсэн хамгийн чухал, эн тэргүүний нийтлэг хэрэгцээтэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тэдгээрийн хэрэглээний зардалд эзлэх хувиар жигнэсэн дундаж юм. 2012 озоос эхлэн хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчилж 214 нэр төрөл болгож 2010 оны 12-р сарын үнээр суурилан ХҮИ-ийг тооцож байна.

АЖ ҮЙЛДВЭР

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн ажиллагаагаар нь ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна. Аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгж байгууллагын тайлангийн хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм. Аж үйлдвэрийн нийт бүтээгдхүүний өсөлтийг гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг 2000 оны зэрэгцүүлэх үнээр үнэлж тодорхойлсон болно.

Гол нэр төрлийн бүтээгдхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

ХӨДӨЛМӨР

Ажилгүйчүүдийн тоонд олон улсын сатндартын ангиллын дагуу Монгол улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй эрж, хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн хүмүүс орно.

ЭРҮҮЛ МЭНД

Нялхсын нас баралт / 1 хүртэл насны 1000 хүүхдэд ногдох/-ыг тухайн үед 1 хүртэлх насны нас барсан хүүхдийн тоог тухайн үед амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

ГЭМТ ХЭРЭГ

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд эогдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог гаргахдаа нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог жилийн дундаж 18 ба түүнээс дээш насны хүн амд харьцуулан тооцно.

ХАА-Н САЛБАР

Аймгийн ИТХ-ын 2002 оны ээлжит 8-р хуралдаанаар баталсан бүсүүд:

Баруун бүс: Завхан Наранбулаг, Өлгий, Өмнөговь, Тариалан, Ховд

Хойт бүс: Бөхмөрөн, Даваст, Сагил, Түргэн

Зүүн бүс: Зүүнговь, Малчин, Тэс, Хяргас

Өмнөд бүс: Баруунтуруун, Зүүнхангай, Өндөрхангай, Цагаанхайрхан

Төвийн бүс: Улаангом хот

ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР:

1. Саруудыг ром тоогоо тэмдэглэв .(I, II, III, IV, V..... г.м)
I-XII жилийн эхний тухайн сарыг оруулсан өсөн нэмэгдэх дүнг харуулав.

2. Дараахь тэмдэглэлүүдийг ашиглав :

... мэдээлэл байхгүй

0.0 маш бага тоо

- гүйцэтгэл байхгүй


Д – дахин

3. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрөх тохиолдол байж болно.

НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**1.1 ХҮН АМ**


Энэ оны эхний 11 сард 1912 эхээс 1917 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс төрсөн хүүхдийн тоо 93 - ээр буюу 5.1 хувиар нэмэгдсэн байна.

Гэрийн төрөлт 9 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4 төрөлтөөр цөөн байна.



Хүн амын төрөлт 1917 байгаа нь өмнөх 4 жилийн дунджаас 3.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүн амын нас баралт 435 гарч 1000 хүнд 5.8 ноогдох болсон нь гаралт өнгөрсөн оны мөн үеэс 2.8 хувиар нэмэгдэж, 1000 хүнд ноогдох нь 0.1 пунктээр илүү байна.



Эхний 11 сард 1000 хүн амд ноогдох цэвэр өсөлт 19.8 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 1,4 промилээр өсч, өмнөх 4 жилийн дунджаас 1 промилээр буурсан байна.

1.2 НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ , НӨХӨН ОЛГОВОР

НДС-д шимгэлээр 8329.0 сая төгрөг оруулхаас 8314.8 сая төгрөг оруулж төлөвлөгөөг 99.8 хувиар биелүүлж 0,2 хувиар буюу 14.2 сая төгрөгөөр тасалсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс НДС-ийн орлого 2306 сая төгрөгөөр буюу 38.4 хувиар өссөн байна.

Сангуудаар авч үзвэл орлогын төлөвлөгөөг тэтгэврийн даатгалын сангийн орлого 0.1 хувиар, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 13.6 хувиар, ҮОМШӨ-н даатгалын сангийн орлого 0.1 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна. Харин ЭМД-н сангийн орлого 3.7 хувиар тасарсан байна.


НДС-ийн шимтгэлийн төлөвлөгөөг Баруунтуруун, Бөхмөрөн, Зүүнхангай, Түргэн, Улаангом сумууд 0.4-2.1 хувиар давуулан биелүүлж, бусад бүх сумууд 0.2-8.6 хувиар тасалсан байна.

15.6 тэрбум төгрөг тэтгэвэрт, 2055,7 сая төгрөг ЭМД-ын санхүүжилтэнд зориулан зарцуулж тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн олгосон байна.

НДС 83.3 сая төгрөгийн авлагатай байгаа бөгөөд үүнээс 27.4 сая төгрөгийг төсөвт газраас авах авлага байна. Нийт авлага өнгөрсөн оны мөн үеэс 21.4 сая төгрөгөөр буюу 20.4 хувиар буурсан байна.

Тэтгэмжийн даатгалын сангаас 731.6 сая төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 86.1 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 62.5 сая төгрөг, нийтдээ даатгалын сангуудаас 18.6 тэрбум төгрөг зарцуулсан бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 6346.5 сая төгрөгөөр буюу 51.9 хувиар өссөн байна.

2012 оны 11 сарын нийгмийн даатгалын сангуудын зарцуулалт, бүтцээр



Нийгмийн халамжийн сангаас 2012 оны эхний 11 сард 22.6 мянган хүнд 5.3 тэрбум төгрөг зарцуулснаас халамжийн тэтгэвэрт 1872 хүнд 1905.6 сая, нөхцөлт мөнгөн тэтгэмжинд 1382 хүнд 689.6 сая төгрөг, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэнд үзүүлэх хөнгөлөлт 136,3 сая, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламжинд 432.8 сая, улсын төсвөөс олгосон тэтгэмж, тусламжинд / жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, алдар цолтой ахмадууд, алдарт эхийн одонгийн / 2067.8 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна

Халамжийн сангийн орлого өнгөрсөн оны мөн үеэс 38,5 хувиар, зарцуулалт нь 36,7 хувиар тус тус өссөн байна. Асрамжийн газар нийт 18 хүн асуулж байгаа бөгөөд 10 эмэгтэй, 2 хүүхэд байна.

Асрамжийн үйл ажиллагаанд нийт 241.1 сая төгрөгийг зарцуулжээ.


1 хүнд 1174.2 мянган төгрөгийн нөхөн олговор олгогдсон байна.

1.3 АЖИЛГҮЙ ИРГЭД

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн ажил идэвхитэй хайж байгаа ажилгүй хүний тоо 1004 болж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 74.6 хувиар буюу 429 хүнээр нэмэгдсэн байна. Аймгийн хэмжээнд 569 эмэгтэй ажил идэвхитэй эрж байгаа нь ажилгүйчүүдийн 56.7 хувийг эзэлж байна.

Оны эхний 11 сарын байдлаар бүртгүүлсэн, ажил идэвхитэй эрж байгаа ажилгүйчүүдийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 33,7 хувиар буюу 511 ажилгүйчүүдээр буурсан байна.

Ажилгүйчүүдийн тоо сүүлийн 5 жилээр



Ажилгүйчүүдийн 23.8 хувь нь дээд, 10.9 хувь нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны 57.0 хувь нь бүрэн дунд ба суурь боловсролтой, 8.4 хувь нь бага болон боловсролгүй хүмүүс эзэлж байна.


Ажил идэвхитэй хайж байгаа хүмүүсийн 54,7 хувь нь 15-34 насны залуучууд байна.

16 дээш насны арван мянган хүнд 209 ажилгүйчүүд ноогдож байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 74.1 хувиар өссөн байна.

1.4 ЭРҮҮЛ МЭНД

Аймгийн хэмжээнд оны эхний 11 сард нэг хүртэлхи насандаа 29 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 17 хүүхдээр цөөн, 1 - 5 хүртэлхи насны 9 хүүхэд эндэж өмнөх оны мөн үеийнхээс 16 хүүхдээр цөөн байна.

Жирэмслэлт болон төрөлтийн улмаас эхийн эндэгдэл гараагүй байна.



5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин Давст 200, Наранбулаг 176,5, Түргэн 100, Сагил 95,2 Цагаанхайрхан 76,9, Малчин 52,6, Бөхмөрөн 45,5, Ховд 37, Завхан 37, байгаа нь аймгийн дунджаас 17,2 – 180,2 промилээр өндөр, Улаангом, Өндархангай, Тариалан сумдууд аймгийн дунджаас 0,2-4,9 промилээр бага, бусад сумдад гараагүй байна.




0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 29 гарч нялхсын эндэгдлийн түвшин 15,1 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс гаралт 17 - өөр, 1000 амьд төрөлтөнд ноогдох эндэгдэл 10,1 промилээр буурсан байна. Өмнөх 4 жилийн дунджаас нялхсын эндэгдлийн түвшин 12,8 промилээр, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 14,5 промилээр тус тус буурсан байна.



Нялхсын эндэгдлийн түвшин Давст, Цагаанхайрхан, Малчин, Бөхмөрөн, Ховд, Завхан, Өндөрхангай, Тариалан, Өмнөговь сумдад аймгийн дунджаас 2,8 – 184,9 промилээр өндөр, Улаангом суманд аймгийн дунджаас 2,1 промилээр бага, бусад сумдад гараагүй байна.

Нийт нас баралтын 18,8 хувийг эмнэлгийн нас баралт эзэлж, өнгөрсөн оны мөн үеэс 1,7 пунктээр буурсан байна.

Осол гэмтлийн улмаас 58 хүн нас барж, өвчлөгчдийн тоо 535 байна. Осол гэмтлийн улмаас нас барагчдын тоо өмнөх 3 жилийн дунджаас 4.9 хувиар өсч, өвчлөгсдийн тоо 28,8 хувиар буурсан байна.




Хорт хавдраар өвчлөгчдийн тоо 99 болж, 119 хүн нас барсан байна.




Хорт хавдраар өвчлөгсдийн тоо өмнөх 3 жилийн дунджаас 16,1 хувиар буурч, нас барагсдын тоо мөн 11,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 612 болж өнгөрсөн оны мөн үеэс 46,6 хувиар буюу 535 гаралтаар буурсан байна. Мөн үеийн халдварт өвчний гаралт өмнөх 4 жилийн дунджаас 28.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Халдварт өвчний гаралт




Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнүүд, 2012 оны эхний 11 сар, хувиар





Хүн амд зонхилон тохиолдох халдварт өвчнийг хувиар авч үзвэл гепатит өвчин өмнөх оны мөн үед нийт халдварт өвчний 67,4 хувийг эзэлж байсан бол энэ оны 11 сарын байдлаар 34,2 хувиар буурч, харин БЗХӨ 18,1, салхинцэг 4,8 хувиар тус тус өссөн байна.

10000 хүн тутмаас 82,2 нь халдварт өвчнөөр өвчилж байгаа бөгөөд Зүүнхангай /148/, Давст /135,6/ Улаангом /132,7/, Хяргас /129,7/, Сагил /116,1/, Өлгий /86,2/, Түргэн /83,9/ сумдад аймгийн дунджаас 1,7 – 65,8 процедибилиэр дээгүүр, бусад сумдад аймгийн дунджаас 6 – 76,2 процедибилиэр доогуур байна.





Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 33,2 хувь нь гепатит, 29,7 хувь нь БЗХӨ, 8,9 хувь нь сүрьеэгээр, 6,7 хувь нь мөөгөнцрөөр, 1,1 хувь нь гахайн хавдар, 20,5 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилжээ.





Өнгөрсөн оны мөн үеэс трихоминиаз 25, салхинцэцэг 8, бруцеллөз 26, тэмбүү 6, хүйтэн 1, мөөгөнцөр 1 гаралтаар нэмэгдэж, гепатит 570, хамуу 4, гахайн хавдар 9, сүрьеэ 5 гаралтаар тус тус буурч, цусан суулга өвчин өнгөрсөн оны мөн үеийн түвшинд буюу 4 гарсан бол өнгөрсөн оны мөн үед 2 байсан мэнэн өвчин гараагүй байна.




Амбулаториор 297,0 мянган хүнд үзлэг хийгдэж, 17,6 мянган хүн хэвтэн эмчлэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс амбулаториор үйлчлүүлсэн хүн 8,0 мянган хүнээр их, хэвтэн эмчлүүлэгчид өнгөрсөн оны мөн үеэс 380 хүнээр цөөн байна.

Хувийн хэвшлийн 12 эмнэлэгээр энэ оны эхний 11 сард нийт 12540 хүн үзлэг, эмчилгээ, оношлогоо хийлгэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 453 хүнээр цөөн байна. Мөн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний орлого 83,1 сая төгрөг байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 18,3 төгрөгөөр буюу 28,0 хувиар өссөн байна.

1.5 ГЭМТ ХЭРЭГ

Оны эхний 11 сард бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 285 болж өнгөрсөн оны мөн үеэс 9.8 хувиар, өмнөх 4 жилийн дунджаас 91 гэмт хэргээр буюу 24.2 хувиар тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 11 сараар



Гэмт хэргийн өнгөөр авч үзвэл өнгөрсөн оны мөн үеэс хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 7.3 хувиар өссөн бөгөөд, үүнээс бусдын бие, махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг 7.7 хувиар өсч, хүнийг санаатай алах гэмт хэрэг 50.0 хувиар буурчээ.


Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 8.6 хувиар буурсан бөгөөд үүнээс нийт хулгайн гэмт хэрэг 4,3 хувиар, иргэдийн өмчийн хулгайн 40.8 хувиар тус тус буурч, малын хулгайн гэмт хэрэг 16,7 хувиар, бусад хулгайн гэмт хэрэг 50.0 хувиар тус тус өссөн байна. Залилангийн гэмт хэрэг 16.7 хувиар, бусад өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 12.5 хувиар тус тус буурсан байна.

Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг 42.9 хувиар, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 50.0 хувиар, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг 33.3 хувиар, захиргааны журмын эсрэг гэмт хэрэг 83.3 хувиар, шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг 60.0 хувиар тус тус буурсан бөгөөд аж ахуйн нэгжийн эсрэг гэмт хэрэг 2.5 дахин, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2.7 дахин, тээврийн хэрэгслийн ХАБ, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10.0 хувиар тус тус өссөн байна.

Өмнөх оны 11-р сард гарч байгаагүй тээврийн хэрэгслийн хулгайн гэмт хэрэг нэг тохиолдол гарсан байна.

Оны эхний 11 сард 254 хүн гэмт хэрэгт холбогдон шалгагдсаны 5,1 хувь буюу 13 нь эмэгтэйчүүд, 5,9 хувь буюу 15 нь насанд хүрээгүй хүүхдүүд эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үеэс гэмт хэрэгт холбогдсон хүмүүс 23.5 хувиар, эмэгтэйчүүдийн тоо 45.8 хувиар, насанд хүрээгүй хүүхдүүд 34.8 хувиар тус тус буурсан байна.


Гэмт хэргийн 31.2 хувь нь согтуугаар, 19.3 хувь нь бүлэглэж үйлдэгдсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 7.2 хувиар өсч, бүлэглэж үйлдэгдсэн гэмт хэрэг 32.9 хувиар буурсан байна.



Эхний 11 сарын байдлаар гэмт хэргийн илрүүлэлт 60 хувьтай байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үед гэмт хэргийн 74,7 хувийг илрүүлж байсантай харьцуулахад 14,7 пунктээр буурсан байна. Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллагад 470 сая төгрөгийн хохирол учирч өнгөрсөн оны мөн үеэс 30,1 хувиар өссөн бөгөөд нийт хохирлын 76,9 хувийг нөхөн төлүүлж, нөхөн төлөлтийн хувь өнгөрсөн оны мөн үеэс 13,6 хувиар нэмэгдсэн байна.

Шүүхээр 115 гэмт хэрэгт 177 хүн ял шийтгүүлсэн нь шүүхээр таслуулсан гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 0,9 хувиар өсч, харин шийтгүүлсэн хүний тоо 6,3 хувиар буурсан байна. Шүүхээр таслуулсан гэмт хэргийн тоо өмнөх 4 жилийн дунджаас 16,7 хувиар, ял шийтгүүлсэн хүний тоо 17,7 хувиар тус тус буурсан байна.

Шүүхээр таслуулсан гэмт хэрэг, ял шийтгүүлсэн хүний тоо



II. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД :

2.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ

Хэрэглээний үнийн индекс

Энэ оноос хэрэглээний үнийн индекс тооцох барааны нэр төрлийг 213 болгож суурь оныг 2010 оны 12 сараар тооцох боллоо. Сар бүрийн 15-21 ний байдлаар хүн амын өргөн хэрэглээний 12 бүлэг,

сагсны 213 нэрийн барааны үнийн өөрчлөлтийг судалж сарын инфляци тооцож байдаг. Энэ оны 11-р сарын 15-21 нд судлагдаж буй өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өнгөрсөн оны мөн үеэс 13.5, оны эхнээс 11.5, 2010 оны 12 сар буюу суурь оноос 22.5, өмнөх сараас 1.2 хувиар өссөн байна.

**ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ,
ТАРИФЫН ИНДЕКС 11-р сарын 21-ний байдлаар**

	2012-11 2010-12	2012-11 2011-11	2012-11 2011-12	2012-11 2012-10
ЕРӨНХИЙ ИНДЕКС	122.5	113.5	111.5	101.2
01. ХҮНСНИЙ БАРАА, СОГТУУРУУЛАХ БУС УНДАА	124.5	117.0	112.8	102.1
02. СОГТУУРУУЛАХ УНДАА, ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИС	157.5	155.8	155.8	105.9
03. ХУВЦАС, БӨС БАРАА, ГУТАЛ	128.6	117.7	114.7	100.3
04. ОРОН СУУЦ, УС, ЦАХИЛГААН, ХИЙН БОЛОН БУСАД ТҮЛШ	118.4	109.0	109.0	102.7
05. ГЭР АХУЙН ТАВИЛГА, ГЭР АХУЙН БАРАА	128.2	118.1	115.7	100.6
06. ЭМ, ТАРИА, ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	119.8	111.3	111.3	101.2
07. ТЭЭВЭР	115.1	103.8	102.9	100.0
08. ХОЛБООНЫ ХЭРЭГСЭЛ, ШУУДАНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ	97.1	97.1	97.1	99.4
09. АМРАЛТ, ЧӨЛӨӨТ ЦАГ, СОЁЛЫН БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	104.9	101.4	101.4	100.3
10. БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ	117.9	110.0	110.0	100.0
11. ЗОЧИД БУУДАЛ, НИЙТИЙН ХООЛ, ДОТУУР БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ	142.5	127.7	122.4	100.0
12. БУСАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭ	128.9	115.3	114.5	100.0

Өмнөх сараасаа хүнсний бараа, согтууруулах бус ундааны барааны бүлгийн үнэ тариф 2.1, согтууруулах ундаа тамхины бүлгийн үнэ 5.9, хувцас бөс барааны бүлгийн үнэ 0.3, орон сууц, түлш цахилгааны бүлгийн үнэ 2.7, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 0.6, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.2, амралт чөлөөт цаг соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ 0.3 хувь өсч, холбооны хэрэгсэл, үйлчилгээний үнэ 0,6 хувь буурч бусад бүлгийн үнэ тогтвортой байлаа.


Өмнөх сараасаа 31 бүтээгдэхүүний үнэ 17-5000 төгрөгөөр өсч, 15 бүтээгдэхүүний үнэ 17-3000 төгрөгөөр буурсан байна.

**Гол нэрийн барааны өсөлт,
бууралтын хувь**


	өмнөх сараас	ӨОМҮГ-с
гурил дээд зэрэг	0.0	7.2
гурил, 1-р зэрэг	0.0	6.3
хонины мах	0.0	57.1
үхрийн мах	0.0	57.1
адууны мах	11.0	51.5
ямааны мах	0.0	60.0
хиам	0.0	41.3
сүү	51.9	13.9
тараг	27.3	12.0
ургамлын тос	0.0	4.3
алим	19.0	17.7
мандарин	-19.0	41.7
төмс	11.1	11.1
байцаа	11.1	-23.1
лууван	27.8	27.8
манжин	11.1	-16.7
Бензин, А-80, 1 литр	0.0	10.4
Бензин, А-92, 1 литр	0.0	-1.1
Дизелийн түлш, 1 литр	0.0	5.0

Өмнөх сараасаа адууны мах 11.0, сүү 51.9, тараг 27.3, алим 19.0, төмс, байцаа 11.1, лууван 27.8, манжин 11.1 хувь өссөн байна.


Өнгөрсөн оны мөн үеэс махны үнэ 51.5-60,0 хувиар, гурилын үнэ 6,3-7,2 хувиар, сүү, тараг 12,0-13,9, хиам 41,3, жимс, жимсгэнэ 17,7-41,7, төмс 11,1, луувангийн үнэ 27,8, А-80 бензин 10,4, дизелийн түлшний үнэ 5,0 хувиар тус тус өсчээ.



Сүүлийн 5 жилийн 11 сарыг оны эхтэй харьцуулсан индексээс харахад 2008 оны 11 сард хамгийн өндөр буюу 26.5 хувийн өсөлттэй, үүний дараа 11,5 хувийн өсөлттэйгээр 2012 оны 11 сар тооцогдож байна. 2009, 2010, 2011 оны өдийд 4,4 – 7,5 хувийн өсөлттэй байсан байна.



Сүүлийн 5 жилийн 11-р сарыг өмнөх сартайгаа харьцуулсан индексээс харахад 2009 оны 11 сард хамгийн өндөр буюу 7.0 хувийн өсөлттэй, 2008 оны 11 сард 0.3 хувийн бууралттай байсан байна.



2012 он гарсаар 1, 2 дугаар саруудад өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф өмнөх сараасаа 1.5 , 3 дугаар сард өмнөх сараасаа 0.1, 5 дугаар сард өмнөх сараасаа 0.8, 6-р сард өмнөх сараасаа 1.1 , 7-р сард өмнөх сараасаа 1.0 , 8-р сард өмнөх сараасаа 0.7, 9-р сард өмнөх сараасаа 1.1, 10 р сард өмнөх сараасаа 1.0, 11 р сард өмнөх сараасаа 1.2 хувиар өсч, 4 дүгээр сард 0.1 хувиар буурсан байна.



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулснаар барааны бүлгүүдээр үнийн өөрчлөлтийн тооцож үзвэл :


Хүнсний бараа, ундаа ус 17.0 %	Хүнсний бараа, ундаа усны бүлгийн үнэ дүнгээрээ 17.0 хувь өссөн нь талх,гурил, будааны бүлгийн үнэ 6.9 %, мах махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 55.8,сүү сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 7.9,өөх тосны дэд бүлгийн үнэ 2.4, жимс жимсгэний дэд бүлгийн үнэ 20.6, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ 6.5,чихрийн дэд бүлгийн үнэ 15.0, хүнсний бусад бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 11.8,согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 16.5 хувь өссөнтэй холбоотой байна.
Согтууруулах ундаа, тамхи 55.8 %	Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 55.8 % өссөн нь согтууруулах ундааны дэд бүлгийн үнэ 44.9, тамхины дэд бүлгийн үнэ 70.5 хувь өссөнтэй холбоотой байна.
Хувцас гутал бөс бараа, гутал 17.7 %	Хувцас, гутал, бөс барааны бүлгийн үнэ дүнгээрээ 17.7 хувь өссөн нь хөвөн бөс барааны бүлгийн үнэ 18.9, үүнээс бүх төрлийн хувцасны дэд бүлгийн үнэ 20.4 % үүнээс жижиг эдлэл хэрэгслийн дэд бүлгийн үнэ 4.1, гутлын дэд бүлгийн үнэ 14.9 хувь өссөнтэй холбоотой байна.
Орон сууц, ус 9.0 %	Орон сууц, түлш цахилгааны бүлгийн үнэ дүнгээрээ 9.0 хувь өссөн нь орон сууцны засвар үйлчилгээний дэд бүлгийн үнэ 6.7, усан хангамж болон орон сууцны үйлчилгээний бүлгийн үнэ 16.8, цахилгаан болон бусад түлшний бүлгийн үнэ 11.7 хувь өссөнтэй холбоотой байна.
Гэр ахуйн бараа, тавилга 18.1 %	Гэр ахуйн бараа, тавилганы бүлгийн үнэ дүнгээрээ 18.1 хувь өссөн нь гэрийн тавилганы бүлгийн үнэ 22.5 , цахилгаан барааны бүлгийн үнэ 5.9 ,гэр ахуйн шилэн эдлэл, сав суулганы барааны бүлгийн үнэ 47.8 , оёмол, нэхмэл эдлэлийн үнэ 17.8, гэр ахуйн цэцэрлэгийн зориулалттай хөдөлмөрийн багаж хэрэгслийн бүлгийн үнэ 8.5,гэр ахуйн цэвэрлэгээний болон бусад жижиг барааны бүлгийн үнэ 17.6 хувь өссөнтэй холбоотой байна.
Эм тариа эмнэлгийн үйлчилгээ 11.3 %	Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 11.3 хувь өссөн нь эм тариа эмнэлгийн хэрэгслийн үнэ 11.3, амбулаторийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.0 хувиар өссөнтэй холбоотой байна.
Тээвэр 3.8 %	Тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 3.8 % өссөн нь хувийн тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээний дэд бүлгийн үнэ 2.9 %, тээврийн үйлчилгээний үнэ 4.9 хувь өссөнтэй холбоотой байна.
Холбооны үйлчилгээ -2.9 %	Холбооны үйлчилгээний үнэ тариф 2.9 хувь буурсан нь холбоо шуудангийн үйлчилгээний үнэ тариф 2.9 хувиар буурсантай холбоотой байна.
Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээ 1.4 %	Амралт чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 1.4 % өссөн нь чөлөөт цаг соёлын үйлчилгээний бүлгийн үнэ 1.4 хувь буурч, ном сонин бичгийн хэрэгслийн дэд бүлгийн үнэ 3.5 хувь өссөнтэй холбоотой байна.
Боловсролын үйлчилгээ 10.0 %	Боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.0 % өссөн нь их дээд сургуулийн төлбөр 10.0 хувиар өссөнтэй холбоотой байна.
ЗБ нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 27.7 %	Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 27.7 % өссөн нь нийтийн хоолны үйлчилгээний дэд бүлгийн үнэ 22.1 хувь, зочид буудлыг үнэ 60 хувь өссөнтэй холбоотой байна.
Бусад бараа үйлчилгээ 15.3 %	Бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 15.3 % өссөн нь хувь хүний эд зүйл хэрэглэлийн дэд бүлгийн үнэ 40.5 , хувь хүнд хандсан үйлчилгээ 12.4 хувь өссөнтэй холбоотой байна.

Үнийн мэдээллийг сайжруулж, өргөжүүлэхийн тулд өргөн хэрэглээний 11 бараа, бүтээгдхүүний үнийг 7 хоног бүрийн 3 дахь өдөр бүр цуглуулж өөрчлөлтийг судалж байна. 2012 оны 11 – р сарын 30-ны байдлаар Улаангом хотын хүнсний зах, дэлгүүрт худалдаалагдаж байгаа хүнсний гол нэрийн барааны үнийг дүнгээр нь өмнөх 10 дугаар сарын дундаж үнэтэй харьцуулахад 2.2 хувь өссөн байна.

Өмнөх сарын дундаж үнээс элсэн чихэр, хонины мах 1.9, шингэн сүү 46.8 хувиар өссөн байна. Махны дундаж үнэ : 2012 оны 11-р сарын 30-ны байдлаар хонины махны үнэ 10-р сарын дундаж үнээс 1.9 хувиар өсч, ямааны мах 4.0 хувиар буурсан байна.

11 - р сард дунджаар 1 кг хонины мах 5400, үхрийн мах 5500, ямааны мах 3800, 1 л шингэн сүү 1360 төгрөгийн үнэтэй байсан байна.





2.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

2.2.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулан тооцсоноор оны эхний 11 сард аймгийн төсөвт 8.6 тэрбум төгрөг оруулахаас 9.3 тэрбум төгрөгийн орлого орж төлөвлөгөөний биелэлт 107.5 хувьтай, 644.7 сая төгрөгөөр давуулан биелүүллээ.

Улсын төсвийн шилжүүлэг, дэмжлэгийг оруулалгүйгээр аймаг өөрөө 7.8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээс 7.7 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж төлөвлөгөөг 99.7 хувиар биелүүлж, 0,3 хувь буюу 22,8 сая төгрөгөөр тасарч байна.

Үүнээс улсын төвлөрсөн төсөвт 3.8 тэрбум төгрөгийг татвар, орлогын хэлбэрээр төвлөрүүлэхээс 3.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлж төлөвлөгөөг 82,8 хувиар биелүүлж, 17.2 хувь буюу 657,9 сая төгрөгөөр тасаллаа. Аймгийн төсөвт өөрийн орлогоор 3,9 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс 4.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 116,2 хувиар биелүүлж, 16.2 хувь буюу 635,1 сая төгрөгөөр давуулсан байна.


Ноднингийн мөн үетэй харьцуулахад аймгийн төвлөрүүлсэн орлого 3,3 хувиар буюу 266,2 сая төгрөгөөр бага, үүнээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлого 37 хувиар буюу 1.9 тэрбум төгрөгөөр бага, аймгийн төсөвт төвлөрүүлсэн орлого 53.7 хувиар буюу 1.6 тэрбум төгрөгөөр илүү байна.

Оны эхний 11 сард улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татварын төлөвлөгөө 28,5 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татварынх 0,3 хувиар давж биелэгдэн харин онцгой албан татвар 32,9 хувиар, агаарын бохирдлын төлбөр 11,5 хувиар, ашигт малтмалын нөөцийн төлбөр 66,6 хувиар тус тус тасарч байна.


Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогуудаас эхний 11 сард орлого тодорхойлох боломжгүй иргэний орлого 8,5, газрын төлбөр 14.8 хувиар, ашигт малтмалын нөөцийн төлбөр 68,7, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 40.7 хувиар, рашаан ус ашигласны төлбөр 10,9, тус тус тасарлаа.

Өнгөрсөн оны мөн үеэс улсын тэмдэгтийн хураамж 33.8, агнуурын нөөц ашигласны төлбөр 93,9, рашаан ус ашигласны төлбөр 33,3, хүү торгуулийн орлого 1,1 хувиар бага, хувиараа аж ахуй эрхлэгч иргэдийн орлого 4,1 дахин, цалингийн ашиг 61,2 хувиар, бусад татварын орлого 63,7, авто хэрэгслэлийн татвар 53,7 хувиар, хайгуулын болон ашиглалтын лицензийн төлбөр 2.1 дахин илүү байна.

Аймгийн төсвийн орлогын 50.9 хувийг тусламжийн орлогоор, 36.3 хувийг орлогын албан татвараар, 0.9 хувийг өмчийн албан татвараар /бууны болон машины татвар/, 7,2 хувийг бусад албан татвараар, 3.0 хувийг татварын бус орлогоор тус тус бүрдүүлсэн байна.


Төсвийн орлогын бүтэц, хувиар, 2012 оны эхний 11 сар, хувиар**Төсвийн орлогын бүтэц, хувиар, 2011 оны эхний 11 сар, хувиар**

Ноднингийн мөн үетэй харьцуулахад тусламжийн орлогын эзлэх хувь 18,1 пунктээр буурч, орлогын албан татварын эзлэх хувь 14,8 пунктээр өссөн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, онуудаар

Сүүлийн 5 жилийн эхний 11 саруудын байдлаас харахад аймгийн төсвийн орлогод тусламжийн орлогын эзлэх хувь буурч, орлогын албан татвараар бүрдүүлсэн орлогын эзлэх хувь өсч байна.

Аймгийн өөрөө бүрдүүлэх орлогын хэмжээ жил бүр тасралтгүй өсч ирсэн бөгөөд 2012 оны эхний 11 сарын гүйцэтгэлийг сүүлийн 4 жилийн 11 дүгээр саруудын дундажтай харьцуулахад 42,6 хувиар өссөн байна.



Аймгийн төсвийн нийт зарлагад өөрөө бүрдүүлсэн орлогын эзлэх хувь 15,5 хувь болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 9.3 пунктээр буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 4,5 пунктээр бага байна.



Суурь он буюу 2005 оны эхний 11 сартай харьцуулахад аймаг өөрөө бүрдүүлсэн төсвийн орлого энэ оны эхний 11 сард 7.6 дахин илүү байгаа бөгөөд сүүлийн 5 жилийн дундажтай харьцуулахад 63,6 хувиар өссөн байна. 2005 оны 11 сартай харьцуулахад төсвийн зарлага 7,1 дахин өссөн байна.

Төсвийн орлого, зарлагын өсөлт, 2005. I - XI = 100 %


	2007.I- XI / 2005 .I- XI	2008 I- XI / 2005 I- XI	2009 .I- XI / 2005.I- XI	2010. I- XI / 2005. I- XI	2011.I- XI / 2005.I- XI	2012 .I- XI / 2005.I- XI
Орлого	190,7	287,0	405,6	650,4	784,5	758,3
Зарлага	192,9	289,0	309,8	343,5	459,3	711,4

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА


Орон нутгийн төсвийн болон улсын төсвийн байгууллагуудын дүнгээр 50,0 тэрбум төгрөгийн зардал гаргасан нь өнгөрсөн оны мөн үеэс 54,9 хувиар илүү байна.

Нийт зарлагын 55,3 хувийг цалин хөлсөнд, 5,8 хувийг эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд, 25.9 хувийг бусад зардалд, 8,0 хувийг урсгал шилжүүлэгт, 5.0 хувийг хөрөнгө оруулалтанд зориулан зарцууллаа.

Төсвийн зарлагын бүтэц, 2012 оны эхний 11 сар, хувиар



Төсвийн зарлагын бүтэц, 2011 оны эхний 11 сар, хувиар



Өнгөрсөн оны мөн үеэс хөрөнгө оруулалтын зардлын эзлэх хувь 0.4, урсгал шилжүүлэгийн эзлэх хувь 4.3 пунктээр өсч, цалингийн зардлын эзлэх хувь 1.7 пунктээр, бусад зардлын эзлэх хувь 2.9, пунктээр тус тус буурсан байна.

Төсвийн зардлын 24.6 хувийг төрийн үйлчилгээ, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын үйл ажиллагаанд, 40.4 хувийг боловсрол, 20.1 хувийг эрүүл мэндийн салбарт, 1.0 хувийг нийгмийн даатгал, халамжийн үйл ажиллагаанд, 3.7 хувийг амралт, спортын үйл ажиллагаанд, 0.8 хувийг ХАА-н салбарт, 2.3 хувийг ус цаг уур, байгаль орчны үйл ажиллагаанд, 7.2 хувийг бусад үйл ажиллагаанд зориулан зарцууллаа.

Ноднингийн мөн үетэй харьцуулахад төрийн үйлчилгээний салбарт зориулсан зардлын эзлэх хувь 0.1 пунктээр, эрүүл мэндийн салбарынх 1.6 пунктээр өсч, боловсролын салбарынх 9.5 пунктээр буурсан байна.

Төсөвт байгууллагуудад 5.1 мянган хүн ажиллаж, ажиллагсадын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс 8.8 хувиар өсчээ.

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ӨГЛӨГ, АВЛАГА

Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн байгууллагуудын дүнгээр оны эхний 11 сард 490.6 сая төгрөгийн өртэй, 95.6 сая төгрөгийн авлагатай гарч, өмнөх сараасаа өглөг 14.9 хувиар өсч, авлага 54.1 хувиар буурсан байна. Өнгөрсөн оны мөн үеэс өглөг 37.3 хувиар буюу 133.3 сая төгрөгөөр, авлага 1.3 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр өссөн байна.

11 - р сард 225.2 сая төгрөгийн өр шинээр үүсч, сарын эцэст 87.0 сая төгрөгийн цалингийн, 35.2 сая төгрөгийн эрүүл мэнд, НДШ –ийн, 85.8 сая төгрөгийн түлш, халаалтын, 10.2 сая төгрөгийн цэвэр, бохир усны, 97.2 сая төгрөгийн тээвэр, шатахууны, 44.5 сая төгрөгийн албан томилолтын, 29.7

сая төгрөгийн хоолны, 20.0 сая төгрөгийн эмийн, 6,5 сая төгрөгийн гэрэл цахилгааны, 1.6 сая төгрөгийн шуудан холбооны, 27.8 сая төгрөгийн урсгал засварын, 2.2 сая төгрөгийн байрны түрээсийн, 42.9 сая төгрөгийн бусад зардлын өртэй байна.



Төсөвт байгууллагын өглөг сүүлийн 5 жилийн дунджаас 263,8 сая төгрөгөөр буюу 2,2 дахин өссөн байна.

2012 оны эцэст өргүй гарсан боловч өглөгийн хэмжээ сар бүр нэмэгдэж ялангуяа 5, 6 саруудад хамгийн өндөр түвшинд хүрсэн байна.



2.3 МӨНГӨ, ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Монгол банкны эх үүсвэрээр 33.9 тэрбум төгрөг зузаатгалаар авч, 299.5 тэрбум төгрөг гүйлгээнд гаргаснаас 320.4 тэрбум төгрөгийг буюу гаргасан мөнгөний 106.9 хувийг эргүүлэн татсан байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад зузаатгалаар авсан мөнгө 5.0 тэрбум төгрөгөөр буюу 17.2 хувиар, гүйлгээнд гаргасан мөнгө 82.6 тэрбум төгрөг буюу 38.0 хувиар, гүйлгээнээс татсан мөнгө 103.8 тэрбум төгрөг буюу 47,9 хувиар тус тус өссөн байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 82.5 тэрбум төгрөгт хүрч, үүнээс хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 222.4 сая төгрөг болж ноднингийн мөн үеэс бүх зээлийн үлдэгдэл 18.7 тэрбум төгрөгөөр буюу 29.0 хувиар өсч, хугацаа хэтэрсэн зээл 4.0 сая төгрөгийн буюу 2.0 хувиар буурсан байна.

159.7 сая төгрөгийн найдваргүй зээл байгаа нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.2 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 20.4 сая төгрөгөөр буюу 11.1 хувиар буурсан байна.

Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх 3 жилийн дунджаас 40.9 тэрбум төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна.


Аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл, сая.төг



Зээлийн өрийн үлдэгдлийн хэмжээгээр ХААН, Хас банк тэргүүлж байгаа бөгөөд тэдгээрийн зээлийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 83.5 хувьтай тэнцэж байна.


Төрийн банкны нийт зээлийн 0.04, ХААН банк 0.3, Хас банкны 0.3, Хадгаламж банкны 0.2 хувийг хугацаа хэтэрсэн зээл тус тус эзэлж байна.

Арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэлд эзлэх хувь




Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 37.7 тэрбум төгрөг болж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 35.0 хувиар буюу 9.8 тэрбум төгрөгөөр өсчээ. Сүүлийн 4 жилийн дунджаас иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 20.3 сая төгрөгөөр буюу 2.2 дахин өссөн байна.

Хадгаламжийн үлдэгдэл, сая.төг



Арилжааны банкууд иргэд, аж ахуй нэгжид нийт 58.2 мянган зээлдэгчид 81.8 тэрбум төгрөгийн зээлийг олгосон бөгөөд төрлөөр нь авч үзвэл лизингийн зээл 4.2 хувь, хадгаламж барьцаалсан зээл 15.0 хувь, төслийн зээл 2.2 хувь, малчны зээл 8.5 хувь бизнесийн зээл 20.2 хувь, орон сууцны зээл 4.1 хувь, цалингийн зээл 24.2 хувь, тэтгэвэрийн зээл 13.1 хувийг тус тус эзэлж байна.



2.4 ГАДААД ХУДАЛДАА

Нийт экспорт оны эхний 11-р сард 155,7 мянган ам. доллар болсон бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 2778 мянган ам.доллараар буюу 94.7 хувиар буурсан байна. Гол нэр төрлөөс 42.7 тн адууны мах, 31 ширхэг монгол гэр, 0,6 тн чулуулгын дээж, 960 метр кватрат эсгийг тус тус гаргасан байна. Өнгөрсөн оны мөн үеэс үхрийн мах / 218,7/ огт гаргаагүй, адууны мах 1001,3 тн-оор буюу 95.9 хувиар, чулуулгын дээж 0.93 тн-оор буюу 60.8 хувиар тус тус буурсан бөгөөд монгол гэр 7.8 дахин өссөн байна.

Нийт импорт 45616.4 мян.ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 2510.5 мян,ам,доллараар буюу 5.8 хувиар өссөн байна. 4517 тн гурил, 31.2 мянган тн нефть бүтээгдэхүүн, 67531.4 мян,квт,цаг цахилгаан, 1933 ш мебель тавилга, 635,3 тн овъёс, 38 ш мод

хөрөөдөх машин, 155 тн хивэг, 3.4 тн хүнсний бараа, 26.1 тн чихэр, 56 тн хөц будаа, 36.1 гоймон, 21 тн улаан буудай, 10 тн хүнсний ногоо, 126 мянган л чацарганы жүүс, 31.1 тн моторын тос, 10.8 мянган ш аяга, шаазан, 9 ш ачааны авто машин болон чиргүүл, 2 ш шингэний нөөцлүүр, 120 м³ банз, 30 ш туузан хөрөөний ир, 1 ш автокран, 6 ш торх ба төмөр гангаар хийсэн нөөцлүүрийг тус тус импортоор оруулсан байна.

Өнгөрсөн оны мөн үеэс импортоор оруулсан дизел түлш 4.9 хувиар, цахилгаан 24.3 хувиар, мод хөрөөдөх машин 5.4 дахин, мебель тавилга 34.0 хувиар, авто машин чиргүүл 80.0 хувиар, гурил 17.3 хувиар, овъёс 3.2 дахин, аяга, шаазан 80,0 хувиар, торх ба төмөр гангаар хийсэн нөөцлүүр 20 хувиар тус тус өсч, харин хөц будаа 8.2 хувиар, авто бензин 16.1 хувиар, гоймон 73.2 хувиар, шингэний нөөцлүүр 60.0, хивэг 7,2 хувиар тус тус буурсан байна.

III. ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

3.1 ХӨДӨӨ АЖ АХУЙ

3.1.1 Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дундаж үнэ

Малын үнэ: 2012 оны 11-р сарын 28-ны байдлаар тус аймагт тус аймагт нас гүйцсэн эр ба эм тэмээ 966,7 мянга, өсвөр болон нас гүйцсэн эр ба эм адуу 448,2 – 748,1 мянга, өсвөр насны болон нас гүйцсэн эм ба эр үхэр 512,5 – 859,3 мянга, хурга, өсвөр насны төлөг, нас гүйцсэн эр ба эм хонь 40,0 – 135,8 мянга, ишиг, өсвөр насны борлон, нас гүйцсэн эр ба эм ямаа 26,3 – 85,4 мянган төгрөгийн дундаж үнэтэй байна.

Өмнөх сартай харьцуулахад бод мал, эр ба эм төлөг, эр ямааны үнэ 1,2 – 226,7 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, бусад малын үнэ 0,7 – 10,0 мянган төгрөгөөр буурсан байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бүх насны малын үнэ 6,0 – 420,7 мянган төгрөгөөр өссөн байна.

ХАА-н зарим бүтээгдэхүүн:

Гол нэрийн бүтээгдэхүүн болох тэмээний шир 15000, адууны шир 35000, үхрийн шир 24000, хонины арьс 10000, ямааны арьс 20000, зөгийн бал 20000, өндөг 300, тэмээний мах 4000 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Мал, амьтны гаралтай зарим түүхий эдийн үнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад адууны шир 5,0 мянга, үхрийн шир 3,0 мянга, ямааны арьс 6,0 мянга, өндөг 50 ₮, зөгийн бал 2,0 мянган төгрөгөөр тус тус өсч, хонины арьс 2,5 мянган төгрөгөөр буурсан байна.


Өмнөх сартай харьцуулахад малын арьс, ширний үнэ 1,0 – 10,0 мянган төгрөгөөр өсч, малын гаралтай бусад бүтээгдэхүүний үнэ хэвийн байсан байна.


Газар тариалан болон бусад бүтээгдэхүүн :

Улаан буудай тн нь 475,0 мянга, задгай өвс тн нь 116,7 мянга, хужир шүү тн нь 30,0 мянга, түлээний мод /м3/ 32,1 мянга, аргал тн нь 27,0 мянга, хөрзөн тн нь 35,0 мянга, боодолтой өвс 4166 ₮, өргөст хэмх кг нь 3500 ₮, сонгино кг нь 3000 ₮, чацаргана кг нь 4250 төгрөгийн дундаж үнэтэй байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улаан буудай 25,0 мянга, задгай өвс 3,3 мянга, хужир шүү 64,0 мянга, өргөст хэмх 500 төгрөгөөр буурч, боодолтой өвс, сонгино, чацаргана, түлээний мод 0,2 – 2,8 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмнөх сартай харьцуулахад улаан буудай 136,7 мянга, задгай өвс 21,7 мянга, аргал 2,3 мянга, хөрзөн 2,5 мянга, түлээний мод 246 төгрөгөөр өсч, хужир шүү 50,0 мянга, чацаргана 500 төгрөгөөр буурсан байна.





3.2 АЖ ҮЙЛДВЭР


Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 3,3 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн үеийнхээс 29,9 хувиар буюу 1,4 тэрбум төгрөгөөр буурсан байна.



Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 6,4 тэрбум төгрөг болж, өмнөх оныхоос 3,1 тэрбум төгрөгөөр буюу 32,6 хувиар буурсан байна. Нийт үйлдвэрлэлтийн бууралтанд архины үйлдвэрлэлт, мах болон өлөн гэдэс боловсруулах үйлдвэрлэлийн бууралт нөлөөлсөн байна. Архины үнийн өсөлтөөс шалтгаалж худалдан авалт багассан, үүнээс шалтгаалж архины үйлдвэрлэл 45,7 хувиар, мал махны үнэ өссөнөөс шалтгаалж өлөн боловсруулалт 29,9 хувиар буурч, мах боловсруулж ОХУ-д экспортолдог ААН-үүд үйл ажиллагаа эрхлээгүй байна.

Боловсруулах үйлдвэрлэл өнгөрсөн оны мөн үеэс 44,5 хувиар буурч, үүний дотроос хүнс, ундааны үйлдвэрлэл 55,4 хувиар буурсан байна. Боловсруулах үйлдвэрийн 66,7 хувийг хүнс ундааны үйлдвэрлэл эзэлдэг бөгөөд хүнс ундааны үйлдвэрлэл дотроо 70 орчим хувийг архи, ундааны үйлдвэрлэл эзэлдэг. Иймд архины үйлдвэрлэл буурах нь аж үйлдвэрийн салбарын бууралтанд ихээхэн нөлөөтэй байна. Боловсруулах үйлдвэрлэл, үүний дотроос хүнс, ундааны үйлдвэрлэл сүүлийн 4 жилтэй харьцуулахад он тус бүрээр буурч, сүүлийн 4 жилийн дунджаас 49,6 хувиар буурсан байна.


Нийт үйлдвэрлэлтийн 61,2 хувийг боловсруулах үйлдвэрлэл, 28,0 хувийг эрчим хүч усан хангамж, 10,8 хувийг уул уурхайн салбар эзэлж байна.



Дэд салбараар тооцвол нийт үйлдвэрлэлтийн 40,8 хувийг хүнс ундааны үйлдвэрлэлт, 25,9 хувийг эрчим хүч, дулаан түгээлт, 10,8 хувийг уул уурхайн олборлолт, 5,2 хувийг өлөн гэдэс боловсруулалт, 2,1 хувийг усан хангамж, 1,7 хувийг арьс шир, гутал үйлдвэрлэл, 1,5 хувийг мод

модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл 11,1 хувийг барилгын материалын үйлдвэрлэл, 0,7 хувийг бусад боловсруулах үйлдвэрлэл эзэлж байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтэц /хувиар/



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад аж үйлдвэрийн салбарт эзлэх эрчим хүч түгээлт усан хангамжийн салбар 15,0 пунктээр, уул уурхай олборлолтын салбар 2,2 пунктээр өсч, боловсруулах үйлдвэр 17,2 пунктээр буурсан байна.

Салбарын бүтэц


	2010 XI	2011 XI	2012 XI
Цахилгаан дулаан түгээлт, усан хангамж	14.2	13.0	28.0
Уул уурхай олборлолт	10.8	8.6	10.8
Боловсруулах үйлдвэр	75.0	78.4	61.2
Дүн	100.0	100.0	100.0

Өнгөрсөн оны мөн үеэс /зэрэгцүүлэх үнээр тооцсоноор/ дулаан түгээлт 25.5, усан хангамж 18.7 хувиар өсч, нүүрс олборлолт 11.5, боловсруулах үйлдвэрлэл 44.5 хувиар буурч үүний дотор хүнс ундааны үйлдвэрлэл 55.4 хувиар буурч бусад боловсруулах үйлдвэрлэл 6.9 хувиар өслөө. Барилгын материалын үйлдвэрлэл 18.4, арьс шир гутлын үйлдвэрлэл 45.4, бусад боловсруулах үйлдвэрлэл 10.5 /морин хуур, эсгийн, гэрийн бүрээс, хөшиг, цаваг, хөнжил/, мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл 18.2 хувиар өсч, хувцас үйлдвэрлэл 5.9, өлөн боловсруулалт 29.9 хувиар буурсан байна. Хүнс ундааны үйлдвэрлэл дотроо гурил гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 35.0, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 51.9 хувиар өсч, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл 99.0, архи ундааны үйлдвэрлэл 46.1 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 7.8 тэрбум төгрөг болж өнгөрсөн оны мөн 26,6 хувиар буурсан байна. Нийт борлуулалтын 4,3 хувь буюу 338.6 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд борлуулсан байна.


2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцсоноор суурь үнэ болох 2005 оноос боловсруулах үйлдвэрлэл 2.1д, эрчим хүч усан хангамж түгээлт 46,6 хувиар өсч, уул уурхай олборлох салбар 67,7 хувиар буурсан байна.

**аж үйлдвэрийн бүтээгдэхүүний өсөлт
бууралт/2005 XI =100%/**




Аж үйлдвэрийн салбарын зарим нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтийг 2005 оны мөн үетэй харьцуулбал талх 13.8д, нарийн боов 2.4д, дулаан түгээлт 2.1д, архи 58.8, түгээсэн цэвэр ус 40.9, нүүрс 37.9 хувиар өсч, өлөн боловсруулалт 69,8 хувиар, ундаа үйлдвэрлэл 100,0 хувиар буурсан байна.


**гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт
бууралт /2005=100%/**



гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт 2005=100%/




гол нэрийн бүтээгдэхүүний өсөлт бууралт хувиар 2005=100%



2005 оноос импортын цахилгаан, түүний хэрэглээ 2.1 дахин өссөн байна.

Цахилгааны хэрэглээ



Аж үйлдвэрийн чиглэлийн 77 аж ахуйн нэгж 50 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гол нэр төрлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 21 нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэнд өсөлт гарч, 21 нэрийн

бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурч, өнгөрсөн оны мөн үед үйлдвэрлэгдэж байгаагүй 8 нэрийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, үйлдвэрлэж байсан 12 нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгдээгүй байна.

